



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 29 (602)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Цөмийн энергийн тухай*
- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- *Иргэний хуулийн 10, 11 дүгээр бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвгэл

2009 оны наймдугаар сарын 06 № 29 (602)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

418.	Цөмийн энергийн тухай	679
419.	Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	693
420.	Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	694
421.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	694
422.	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	695
423.	Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	695
424.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	696
425.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	696
426.	Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай	696
427.	Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	697
428.	Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	697
429.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	697

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

430.	Иргэний хуулийн 10, 11 дүгээр бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай	Дугаар 17	698
------	---	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хууль тогтоомж

2.1. Цөмийн энергийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3. Цөмийн эрчим хүч ашиглахтай холбогдсон энэ хуулиар нарийвчлан зохицуулаагүй харилцааг Эрчим хүчний тухай хуулийн² холбогдох зүйл, хэсэг, заалтаар зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "цөмийн энерги" гэж цөмийн хуваагдал болон цөмийн хувирлын дүнд үүссэн энергийг;

3.1.2. "цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах" гэж цөмийн энергийг цөмийн зэвсгээс бусад салбарт ашиглахыг;

¹ Монгол Улсын Үндсэн Хууль-"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Эрчим хүчний тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



3.1.3. "цөмийн болон цацрагийн аюулгүй байдал" гэж хүн ам, байгаль орчныг цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацрагийн бусад үүсгүүрийн нөлөөллөөс хамгаалах, цөмийн төхөөрөмж, цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг хангасныг;

3.1.4. "цацраг идэвхт ашигт малтмал" гэж Ашигт малтмалын тухай хуулийн³ 4.1.2-т заасан уран болон торийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлалыг;

3.1.5. "цөмийн бодис" гэж цөмийн материал болон цөмийн технологид хэрэглэгдэх уран, торийн бүлийн цацраг идэвхт изотоп, газрын ховор элемент агуулсан бодисыг;

3.1.6. "цөмийн төхөөрөмж" гэж цөмийн түлш бэлтгэх үйлдвэр, цөмийн болон судалгааны реактор, цөмийн эрчим хүчний эх үүсвэр, цөмийн түлш болон ашигласан түлш хадгалах байгууламж, баяжуулах үйлдвэр, ашигласан түлшийг дахин боловсруулах үйлдвэрийг;

3.1.7. "ионжуулагч цацраг" гэж шууд болон шууд бус замаар бодис, биологийн биет дотор хос ион үүсгэх цацрагийг;

3.1.8. "цөмийн эрчим хүчний нөөц" гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.21-д заасныг;

3.1.9. "цөмийн эрчим хүч" гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.22-т заасныг;

3.1.10. "цөмийн эрчим хүчний эх үүсвэр" гэж Эрчим хүчний тухай хуулийн 3.1.23-т заасныг;

3.1.11. "цөмийн түлш" гэж цөмийн энерги гаргаж авахад хэрэглэгддэг материалыг;

3.1.12. "цөмийн материал" гэж цөмийн реактор болон цөмийн зэвсэгт ашиглагддаг материалыг;

3.1.13. "цацрагийн үүсгүүр" гэж цөмийн төхөөрөмжөөс бусад цацрагийн шарлага үүсгэгч цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацраг гаргагч аливаа багаж хэрэгслийг;

3.1.14. "цөмийн түлшний материал" гэж цөмийн хуваагдлын дүнд их хэмжээний энерги үүсгэх цөмийн бодисыг;

3.1.15. "цөмийн эх үүсвэр материал" гэж цөмийн түлшний материалыг гарган авах уран, торийн хүдэр, газрын ховор элемент зэрэг түүхий эд материалыг;

3.1.16. "цацраг идэвхт хаягдал" гэж цацраг идэвхийн хэмжээ нь хаягдлын стандартад заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн, ямар ч төлөв байдалд байж болох, цаашид дахин хэрэглэгдэхгүй зүйлсийг;

3.1.17. "шар нунтаг" гэж ураны хүдрийг боловсруулах үйл ажиллагааны явцад завсрын шатанд үүсэх ураны ислийг;

3.1.18. "биет хамгаалалт" гэж Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай Венийн конвенцийн дагуу цөмийн материал болон цөмийн төхөөрөмж рүү зөвшөөрөлгүй этгээд нэвтрэн

орхоос урьдчилан сэргийлсэн арга хэмжээ буюу зохион байгуулалтын нэгдсэн системийг;

3.1.19. "шарлага" гэж цацраг идэвхт бодис, ионжуулагч цацрагийн үүсгүүрээс хүнд үзүүлэх нөлөөллийг;

3.1.20. "мэргэжлийн шарлага" гэж ажлын нөхцөлийн улмаас цацрагтай ажиллагчийн өртөж байгаа аливаа цацрагийн нөлөөллийг;

3.1.21. "тун" гэж ионжуулагч цацрагаас бие махбодид шингээгдсэн энергийн хэмжээгээр тодорхойлогддог цацрагийн шарлагыг илэрхийлэх хэмжигдэхүүнийг;

3.1.22. "цацраг идэвхт хаягдал булшлах" гэж зөвхөн өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлахыг.

4 дүгээр зүйл. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаанд баримтлах зарчим

4.1. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

4.1.1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд харшлахгүй байх;

4.1.2. Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн байх;

4.1.3. олон улсын гэрээнд заасны дагуу зөвхөн энхийн зорилгоор явуулах;

4.1.4. олон улсын болон үндэсний стандартыг чанд мөрдөх;

4.1.5. хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй техник, технологи ашиглах.

5 дугаар зүйл. Цацраг идэвхт ашигт малтмалын өмчлөл болон цацраг идэвхт ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоо

5.1. Монгол Улсын газрын хэвлийд оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмал төрийн өмч мөн.

5.2. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ.

5.3. Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ.

5.4. Энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас илүү хувиар төр хувьцаа эзэмших тохиолдолд уг хувийг төрөөс оруулсан буюу оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

6 дугаар зүйл. Цацраг идэвхт ашигт малтмалын ордын ангилал

6.1. Цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс нь үл хамааран стратегийн ач

³ Ашигт малтмалын тухай хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

холбогдол бүхий ашигт малтмалын ордын ангилалд хамааруулна.

7 дугаар зүйл. Засгийн газрын онцгой бүрэн эрх

7.1. Энэ хуулийн 15.1.2, 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон хувьцаа эзэмшигчийн дараахь асуудлаар гаргасан шийдвэр Цөмийн энергийн комиссын батламжилснаар хүчин төгөлдөр болно:

7.1.1. тухайн компанийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэх;

7.1.2. тухайн компанийн хувьд хувьцаа авах эрхийн бичиг буюу хувьцаанд хөрвөх үнэт цаас шинээр гаргах, эсхүл урьд гаргасан нийт хувьцааны 5 хувиас дээш хэмжээний хувьцаа нэмж гаргах;

7.1.3. тухайн компанийг нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах.

7.2. Энэ хуулийн 15.1.2, 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 7.1-д заасан шийдвэрийг гаргаснаас хойш 14 хоногийн дотор дараахь баримт бичгийг Цөмийн энергийн комисст хүргүүлнэ:

7.2.1. энэ хуулийн 7.1.1-д заасан шийдвэрийн албан ёсны эх хувь, хувьцааг өмчлөл, эзэмшил, ашиглалтдаа авах этгээдийн нэр, хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл болон уг шийдвэртэй холбоотой Цөмийн энергийн комиссоос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

7.2.2. энэ хуулийн 7.1.2-т заасан шийдвэрийн албан ёсны эх хувь, хувьцаа, хувьцаа авах эрхийн бичиг буюу хувьцаанд хөрвөх үнэт цаасыг худалдан авах этгээдийн нэр, хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл болон уг шийдвэртэй холбоотой Цөмийн энергийн комиссоос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

7.2.3. энэ хуулийн 7.1.3-т заасан шийдвэрийн албан ёсны эх хувь, компанийг өөрчлөн байгуулах төлөвлөгөө болон уг шийдвэртэй холбоотой Цөмийн энергийн комиссоос шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

7.3. Цөмийн энергийн комисс энэ хуулийн 7.2-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн шийдвэрийг батламжлах, эс батламжлах шийдвэрийн аль нэгийг гаргана.

7.4. Энэ хуулийн 15.1.2, 15.1.5, 15.1.6-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч мөн хуулийн 7.1, 7.2-т заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛ БОЛОН ЦӨМИЙН ЭНЕРГИ АШИГЛАХ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

8.1. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримтлах бодлогыг батлах;

8.1.2. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;

8.1.3. төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зардлыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх.

9 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

9.1. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах;

9.1.2. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомжийг биелэлтийг зохион байгуулах;

9.1.3. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон Олон улсын атомын энергийн агентлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.1.4. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах талаар нийтлэг дүрэм, журам, зааврыг батлах;

9.1.5. нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, ослын үр дагаврыг арилгах, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах;

9.1.6. нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан тохиолдолд түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах;

9.1.7. цөмийн төхөөрөмж барих газрын байршлыг сонгох;

9.1.8. цөмийн хаягдал, ашиглагдсан цөмийн түлшийг хүн ам, нийгэм, байгаль орчинд аюулгүй хадгалах урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

10 дугаар зүйл. Цөмийн энергийн комисс

10.1. Улсын хэмжээнд цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн



технологи нэвтрүүлэх, судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий орон тооны бус Цөмийн энергийн комисс (цаашид "Комисс" гэх) ажиллана.

10.2. Комиссын дарга нь Ерөнхий сайд, Комиссын орлогч дарга нь цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга байна.

10.3. Комиссын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.

10.4. Комисс нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

11 дүгээр зүйл. Цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний бүрэн эрх

11.1. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн судалгааг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, мэргэжлийн хяналт тавих чиг үүргийг цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/ хэрэгжүүлнэ.

11.2. Төрийн захиргааны байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангах бөгөөд түүний төсөв нь хуулиар хүлээсэн үүрэг, зорилгоо бүрэн хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

11.3. Төрийн захиргааны байгууллага нь цөмийн материал, цөмийн болон ашиглагдахгүй болсон цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах тусгай байгууламжтай байх бөгөөд уг байгууламж нь улсын онц чухал объект байна.

11.4. Төрийн захиргааны байгууллага нь үйл ажиллагаандаа шуурхай албаны автотээврийн хэрэгсэл ашиглах бөгөөд уг автотээврийн хэрэгсэл нь тусгай тэмдэг, дуут болон гэрлэн дохиотой байна.

11.5. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, цацрагтай ажиллагч нь ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд ажлын тусгай хувцас, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг төрийн захиргааны байгууллага батална.

11.6. Төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.6.1. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх;

11.6.2. цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах;

11.6.3. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

11.6.4. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

11.6.5. энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

11.6.6. цөмийн болон цацраг идэвхт хаягдал, цацрагийн үүсгүүрийг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

11.6.7. цөмийн материал, цацраг идэвхт ашигт малтмал, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрмийг батлах;

11.6.8. цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журам, заавар, стандартыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

11.6.9. цөмийн болон цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, ослын үр дагаврыг арилгах, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг мэргэжлийн холбогдох байгууллагатай хамтран боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

11.6.10. хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, баримт бичгийг холбогдох этгээдээс үнэ төлбөргүй гаргуулж авах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналт шалгалтад татан оролцуулах;

11.6.11. цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтөлж, цацрагтай ажиллагчийн өртөж байгаа мэргэжлийн шарлагын тунд хяналт тавих, шарлагын тунгийн мэдээллийн сан бүрдүүлэх;

11.6.12. үйлдвэрлэл, судалгаа, оношлогоо, эмчилгээнд хэрэглэж байгаа цацрагийн үүсгүүр бүхий тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих;

11.6.13. улсын хилээр нэвтрүүлэх цөмийн материал, цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавьж, хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах;

11.6.14. хүрээлэн байгаа орчны болон ахуйн хэрэглээний бараа, материал, хүнсний бүтээгдэхүүн, ундны ус, барилгын материалын цацрагийн түвшний хяналт шинжилгээ хийх, тэдгээр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг тогтоох ажлыг холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран гүйцэтгэх, чанарын баталгаажилтыг хангах арга хэмжээ авах;

11.6.15. цөмийн материалын тооллого, алдагдал, хоргодол, шилжилт хөдөлгөөн хийх журмыг батлах;



11.6.16. энэ хуулийн 28.8-д заасан мэдээллийг нэгтгэн боловсруулж, шаардлагатай бол магадлан шалгаж Олон улсын атомын энергийн агентлагт зохих журмын дагуу хүргүүлэх;

11.6.17. гадаад улс, олон улсын байгууллагатай хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллах;

11.6.18. хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд холбогдох олон улсын байгууллагаас мэргэжлийн туслалцаа, дэмжлэг авах;

11.6.19. ураны баяжмал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн онцлогийг харгалзан түүний хүчин чадал, тоо хэмжээ, шилжилт хөдөлгөөн, тээвэрлэлтийн холбогдолтой нууцлах мэдээллийн жагсаалтыг баталж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах;

11.6.20. энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг геологи хайгуулын ажлын жилийн тайлан болон санхүүгийн тайлан тэнцэлд тулгуурлан баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг газар дээр нь шалгах;

11.6.21. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11.7. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан хайгуулын тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, мөн хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан уурхайн ашиглалтын мэдээ, техник, эдийн засгийн үндэслэлийг түүний хүсэлтээр тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд нууцад хамааруулна.

11.8. Энэ хуулийн 11.7-д заасны дагуу нууцад хамааруулсан мэдээллийг Төрийн нууцын тухай⁴, Байгууллагын нууцын тухай⁵, Хувь хүний нууцын тухай хууль⁶ заасан үндэслэл, журмаас гадуур задруулах, нийтлэх буюу нийтэд мэдээлэхийг хориглоно.

12 дугаар зүйл. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, түүний бүрэн эрх

12.1. Төрийн захиргааны байгууллагад цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

12.2. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

12.3. Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид "улсын байцаагч" гэх)-ийг томилж, чөлөөлно.

12.4. Улсын байцаагч цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр Төрийн хяналт шалгалтын тухай⁷, Захиргааны хариуцлагын тухай хууль⁸ болон бусад хууль тогтоомжид заасан нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

12.5. Улсын байцаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үйл автан гагцхүү хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгон ажиллана.

12.6. Улсын байцаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

12.7. Улсын байцаагч хяналт шалгалт хийх цөмийн төхөөрөмж болон холбогдох бусад объектод свадгүй нэвтрэнэ.

12.8. Улсын байцаагчийн хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлаар бусад этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

12.9. Цөмийн болон цацрагийн хяналт шалгалтыг улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу хийнэ.

13 дугаар зүйл. Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

13.1. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн асуудлаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. цөмийн энергийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

13.1.2. харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрөл олгогдсон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайг зориулалтын дагуу ашиглуулах, гарсан зөрчлийг таслан зогсоох;

13.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүрэг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

13.1.4. цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх талаар харьяалах нутаг дэвсгэртээ сургалт, сурталчилгаа зохион байгуулах.

14 дүгээр зүйл. Хил хамгаалах, гаалийн болон мэргэжлийн хяналтын б а й г у у л л а г а , түүний албан тушаалтны бүрэн эрх

14.1. Хил хамгаалах, гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллага, түүний албан тушаалтан нь хяналт шалгалтаар илэрсэн, зохих зөвшөөрөлгүй цөмийн материал болон цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаар төрийн захиргааны

⁴ Төрийн нууцын тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн
⁵ Байгууллагын нууцын тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн
⁶ Хувь хүний нууцын тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн
⁷ Төрийн хяналт шалгалтын тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн
⁸ Захиргааны хариуцлагын тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн



байгууллага болон хууль хяналтын байгууллагад нэн даруй мэдэгдэж, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

15.1. Дараах үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэнэ:

15.1.1. цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;

15.1.2. цөмийн төхөөрөмж ашиглах;

15.1.3. цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах;

15.1.4. цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах;

15.1.5. цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх;

15.1.6. цацраг идэвхт ашигт малтмал ашиглах;

15.1.7. цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх;

15.1.8. цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

16 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих ерөнхий шаардлага

16.1. Энэ хуулийн 15.1.1-15.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, тус улсад татвар төлөгч компанид олгож болно.

16.2. Энэ хуулийн 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 16.1-д заасан компаниас гадна бусад шаардлагатай аж ахуйн нэгж, байгууллагад олгож болно.

16.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь ерөнхий шаардлагыг бийлүүлнэ:

16.3.1. үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын болон үндэсний стандартыг дагаж мөрдөх;

16.3.2. үйл ажиллагаандаа хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи ашиглах;

16.3.3. үйл ажиллагаа нь ил тод, тогтвортой байх;

16.3.4. болзошгүй ослын хохирлыг арилгах санхүү, эдийн засгийн чадавхитай байх.

17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага

17.1. Энэ хуулийн 15.1.1-15.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч дараахь нөхцөлийг хангасан байна:

17.1.1. техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх;

17.1.2. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан байх;

17.1.3. бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачлагатай оролцдог байх;

17.1.4. компанийн засаглал болон нийгмийн харуцлага, ёс зүйн талаархи дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх;

17.1.5. үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;

17.1.6. ажиллагсдын сургалт, дадлагын асуудлыг шийдэж ирсэн туршлагатай байх.

17.2. Энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч мөн хуулийн 17.1-д зааснаас гадна дараахь нөхцөлийг хангасан байна:

17.2.1. цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх санхүүгийн чадавхитай байх;

17.2.2. байгаль орчны болон биологийн нөхөн сэргээлт хийх санхүүгийн чадавхитай байх;

17.2.3. хариуцлагатай уул уурхайг хөтлөн явуулдаг, энэ талаар зохих туршлага хуримтлуулсан байх;

17.2.4. уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг байх.

17.3. Энэ хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч мөн хуулийн 17.1-д зааснаас гадна дараахь нөхцөлийг хангасан байна:

17.3.1. энэ хуулийн 17.2.1-17.2.4-т заасан нөхцөлийг хангасан байх;

17.3.2. цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор, дэлхийн зах зээлийн үндэс хүргэж борлуулах чадвартай, санхүүгийн хувьд бүрэн бие даасан байх;

17.3.3. цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалт, борлуулалтаар дэлхийн зах зээлд тогтвортой, тэргүүлэх байр суурь эзэлсэн байх;

17.3.4. цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт хийх санхүүгийн чадавхитай байх;

17.3.5. цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай байх;

17.3.6. цацраг идэвхт ашигт малтмалын ордон нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой байх;

17.3.7. цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа эдийн засгийн илүү үр ашигтай, дэвшилтэт технологи ашигладаг байх;

17.3.8. цөмийн технологи нэвтрүүлэх чадвартай байх.

17.4. Энэ хуулийн 15.1.7, 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч мөн хуулийн 17.1.1, 17.1.2, 17.1.4, 17.1.5-д заасан нөхцөлийг хангасан байна.

18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох журам

18.1. Энэ хуулийн 15.1.1-15.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг мөн хуулийн 17.1-д заасан нөхцөлийг хамгийн сайн хангасан тусгай зөвшөөрөл хүсэгчид олгоно.

18.2. Энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг мөн хуулийн 17.2-т заасан нөхцөлийг хамгийн сайн хангасан бөгөөд энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрөл хүсэгчид олгоно.

18.3. Энэ хуулийн 18.5-д зааснаас бусад тохиолдолд мөн хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 17.3-т заасан нөхцөлийг хамгийн сайн хангасан бөгөөд энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрөл хүсэгчид олгоно.

18.4. Энэ хуулийн 15.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг мөн хуулийн 17.4-т заасан нөхцөлийг хамгийн сайн хангасан тусгай зөвшөөрөл хүсэгчид олгоно.

18.5. Энэ хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь тохиолдолд давуу эрхээр олгож болно:

18.5.1. энэ хуульд заасан нөхцөл, шаардлага хангасан бөгөөд мөн хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрсөн цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр хайгуулын ажил хийж, нөөцийг нь тогтоон, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн хайгуулын талбайд цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бол;

18.5.2. тухайн уурхайн цацраг идэвхт ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн нөөцийн 10 хувиас багагүй хэмжээтэй тэнцэх мөнгөн төлбөрийг улсын төсөвт нэг удаа, шууд төлөхийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ хуулийн 18.5.1-д зааснаас бусад хайгуулын талбайд цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан бол.

18.6. Энэ хуулийн 18.5.2-т заасан тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 17.3-т заасан нөхцөлийг хангасан бөгөөд энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрсөн байна.

18.7. Энэ хуулийн 18.5.2-т заасан мөнгөн төлбөрийн хэмжээг тогтооходоо цацраг идэвхт ашигт малтмалын олон улсын зах зээлийн үнийн сүүлийн 6 сарын дундаж ханшийг харгалзан тогтооно.

18.8. Энэ хуулийн 15.1.1-15.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тагнуулын төв байгууллагын саналыг авсан байна.

18.9. Төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж тусгай зөвшөөрөл олгох

эсэх тухай асуудлыг үйл ажиллагааны онцлогийг харгалзан энэ хуулийн 15.1.1-15.1.4, 15.1.6, 15.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 6-12 сар, 15.1.5, 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1-3 сарын дотор шийдвэрлэнэ.

18.10. Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл олгохоос татгалзан тохиолдолд үндэслэлийг зааж бичгээр харуу өгнө.

18.11. Төрийн захиргааны байгууллага шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт 5:1-ийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх эрхтэй.

19 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах журам

19.1. Энэ хуулийн 15.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн⁶ 11.1.1-11.1.3-т зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

19.1.1. эрхлэх үйл ажиллагааны зорилго, төрөл, үндсэн чиглэл, техник, эдийн засгийн үндэслэл, мэргэжлийн боловсон хүчний танилцуулга, дотоод хяналтын ажилтан болон цацрагтай ажиллагчийн мэргэшлийн бэлтгэл, сургалтын гэрчилгээ;

19.1.2. эрхлэх үйл ажиллагаанд холбогдох аюулгүй ажиллагааны олон улсын стандартын шаардлагад нийцсэн иж бүрэн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө;

19.1.3. үйл ажиллагаа эрхлэх байрны цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүйн стандартын шаардлага хангасан талаархи төрийн захиргааны байгууллагын үнэлгээ;

19.1.4. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

19.1.5. байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

19.1.6. цөмийн болон цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө;

19.1.7. цөмийн болон цацрагийн аюулгүй байдалд дотоодын хяналт тавих алба, эсхүл хариуцсан ажилтныг томилсон тухай шийдвэр;

19.1.8. болзошгүй цөмийн болон цацрагийн осол, сүйрлийн хор уршгийг арилгахад шаардлагатай нөөц боломж, хүч хэрэгслийн тухай танилцуулга;

19.1.9. цацрагийн хэмжилтийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гэрчилгээ, үндсэн үзүүлэлт.

19.2. Энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна Эрчим хүчний тухай хуулийн 21.2-т заасан баримт бичгийг бүрдүүлэн, эрхлэх үйл ажиллагаанд шаардлагатай кадастрын зураглалыг хавсаргана.

19.3. Энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

⁶ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль – Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийлэгдсэн



19.3.1. энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрснөө нотолсон албан ёсны шийдвэр;

19.3.2. Ашигт малтмалын тухай хуулийн 18.2-т заасан баримт бичиг.

19.4. Энэ хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

19.4.1. энэ хуулийн 19.3.1-д заасан шийдвэр;

19.4.2. Ашигт малтмалын тухай хуулийн 25.1-д заасан баримт бичиг.

19.5. Энэ хуулийн 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь мөн хуулийн 19.1-д зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

19.5.1. ашиглах цацрагийн үүсгүүр, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйлдвэрийн гэрчилгээ, үндсэн үзүүлэлтүүд;

19.5.2. цацрагийн үүсгүүрийн чанарын баталгаажилтын гэрчилгээ.

19.6. Төрийн захиргааны байгууллага нь өргөдлийг хүлээн аваад дараахь ажиллагааг явуулна:

19.6.1. өргөдлийг бүртгэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх;

19.6.2. өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах.

19.7. Энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн хувьд төрийн захиргааны байгууллага нь мөн хуулийн 19.6-д заасан ажиллагаанаас гадна Ашигт малтмалын тухай хуулийн 26.2-т заасан ажиллагааг явуулна.

19.8. Төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл олгосон тухай ажлын 5 өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ашигт малтмалын болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага болон олон нийтэд тус тус мэдээлнэ.

20 дугаар зүйл. Төлбөр, хураамж

20.1. Энэ хуулийн 15.1.1-15.1.4, 15.1.7, 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн¹⁰ 15.7-д заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж төлнө.

20.2. Энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 32.2-т заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр төлнө.

20.3. Энэ хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь төлбөрийг төлнө:

20.3.1. Ашигт малтмалын тухай хуулийн 32.3-т заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр;

20.3.2. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.

20.4. Энэ хуулийн 20.2, 20.3.1-д заасан тусгай зөвшөөрлийн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу төлнө.

20.5. Энэ хуулийн 20.2, 20.3.1-д заасан тусгай зөвшөөрлийн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу хуваарилна.

20.6. Энэ хуулийн 20.3.2-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хуваарилна.

21 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа

21.1. Энэ хуулийн 15.1.1, 15.1.3-15.1.5, 15.1.7, 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тухайн үйл ажиллагааны онцлог, хяналт шалгалтын үр дүнг харгалзан 3 жил хүртэл хугацаагаар олгоно.

21.2. Энэ хуулийн 15.1.2, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг техник, эдийн засгийн үндэслэл, хяналт шалгалтын үр дүнг харгалзан 20 жил хүртэл хугацаагаар олгоно.

22 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж

22.1. Энэ хуулийн 15.1.1, 15.1.3-15.1.5, 15.1.7, 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 1-ээс доошгүй сарын өмнө түүний хугацааг сунгуулах тухай өргөдлийг төрийн захиргааны байгууллагад гаргаж болно.

22.2. Энэ хуулийн 15.1.2, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 2-оос доошгүй жилийн өмнө түүний хугацааг сунгуулах тухай өргөдлийг төрийн захиргааны байгууллагад гаргаж болно.

22.3. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 22.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянан, зөрчилгүй бол үйл ажиллагааны онцлогийг харгалзан тусгай зөвшөөрлийг 3 жил хүртэл хугацаагаар сунгаж, энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.

22.4. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 22.2-т заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 60 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг хянан, зөрчилгүй бол үйл ажиллагааны онцлогийг харгалзан тусгай зөвшөөрлийг 20 жил хүртэл хугацаагаар сунгаж, энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэнэ.

¹⁰ Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1993 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн

22.5. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

22.5.1. тусгай зөвшөөрлийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

22.5.2. улсын тэмдэгтийн хураамж, эсхүл тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн баримт;

22.5.3. энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах өргөдлийн хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 22.1.1-22.1.4-т заасан баримт бичиг;

22.5.4. энэ хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах өргөдлийн хувьд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хянасан тухай баримт.

22.6. Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан шийдвэрийг ажлын 5 өдөрт багтаан энэ хуулийн 19.8-д заасан байгууллага болон олон нийтэд мэдээлнэ.

23 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

23.1. Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлнэ.

24 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл шилжүүлэхийг хориглох

24.1. Тусгай зөвшөөрөл болон энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно.

25 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх

25.1. Энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд үүссэн талбайн хилийн маргааныг Ашигт малтмалын тухай хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

25.2. Энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хооронд гарсан маргааныг Ашигт малтмалын тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

26 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

26.1. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.1.1-15.1.4, 15.1.7, 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:

26.1.1. компани татан буугдсан, эсхүл иргэн нас барсан;

26.1.2. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

26.1.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

26.1.4. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

26.2. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:

26.2.1. энэ хуулийн 26.1-д заасан үндэслэл бий болсон;

26.2.2. Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-56.1.5-д заасан үндэслэл бий болсон;

26.2.3. энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан тусгай зөвшөөрлийн хувьд мөн хуулийн 29.4-т заасан үндэслэл бий болсон.

26.3. Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл тогтоогдоноос хойш ажлын 10 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрөл хүчингүй болгох үндэслэлийг тодорхой заана.

26.4. Энэ хуулийн 26.3-т заасан тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлийг зөвшөөрөхгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигч түүнийгээ нотлох баримт бичгийг төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

26.5. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26.4-т заасан нотлох баримт бичгийг хянаж үндэслэлтэй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг хүчингүй болгох ба үндэслэлгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, энэ тухай шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ.

26.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 26.5-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд шүүх тухайн шийдвэрийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн¹¹ 46.1.3-т заасны дагуу түдгэлзүүлж болохгүй.

26.7. Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг ажлын 5 өдөрт багтаан энэ хуулийн 19.8-д заасан байгууллага болон олон нийтэд мэдээлнэ.

27 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл дуусгавар болох үндэслэл

27.1. Тусгай зөвшөөрөл дараахь үндэслэлээр дуусгавар болно:

27.1.1. тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан;

27.1.2. энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгсөн;

27.1.3. төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

27.2. Энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан өгсөн тохиолдолд талбайн тухайн хэсгийн хувьд тусгай зөвшөөрөл нь дуусгавар болно.

¹¹ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль-Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 3 дугаарт нийтлэгдсэн



27.3. Тусгай зөвшөөрөл дуусгавар болсноор тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөгдөхгүй.

27.4. Тусгай зөвшөөрөл дуусгавар болоход түүнийг эзэмшиж байсан этгээд тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны байгууллагад буцааж өгнө.

28 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

28.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь нийтлэг эрхтэй:

28.1.1. цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах асуудлаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;
28.1.2. хууль тогтоомжид заасан бусад эрх.

28.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь нийтлэг үүрэгтэй:

28.2.1. цөмийн энергийн тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргаан Зэсгийн газрын шийдвэр, дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөх;

28.2.2. Олон улсын атомын энергийн агентлагаас тогтоосон техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан үйл ажиллагаа явуулах;

28.2.3. цөмийн болон цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллах;

28.2.4. төрийн захиргааны байгууллага, улсын байцаагчаас таьсан хууль ёсны шаардлагыг хугацаанд нь биелүүлж хариу мэдэгдэх, илэрсэн зөрчлийг бүрэн арилгах арга хэмжээ авах;

28.2.5. цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий дотоод хяналтын нэгж байгуулан, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

28.2.6. төрийн захиргааны байгууллагаар батлуулсан цөмийн болон цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрмийг мөрдөж ажиллах;

28.2.7. цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий ажилтан солигдсон тохиолдолд энэ талаар төрийн захиргааны байгууллагад ажлын 3 өдрийн дотор бичгээр мэдэгдэх;

28.2.8. цөмийн материалын бүртгэл, хяналтын талаархи үнэн, бодит мэдээллийг төрийн захиргааны байгууллагад өгөх;

28.2.9. цацрагийн түвшний тухай мэдээллийг төрийн захиргааны байгууллагын шаардсанаар тухай бүр гаргаж өгөх;

28.2.10. тусгай зөвшөөрөл болон түүнийг авахад бүрдүүлсэн материалд заасан аливаа мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд энэ талаар ажлын 5 өдрийн дотор төрийн захиргааны байгууллагад бичгээр мэдэгдэх;

28.2.11. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

28.3. Энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 28.1-д зааснаас гадна дараахь эрхтэй:

28.3.1. хайгуулын талбайн хилийн дотор энэ хуулийн дагуу цацраг идэвхт ашигт малтмал эрх, хайх.

28.4. Энэ хуулийн 15.1.5-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 28.2-т зааснаас гадна дараахь үүрэгтэй:

28.4.1. хайгуулын талбайн хилийн дотор цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрх, хайх;
28.4.2. Ашигт малтмалын тухай хуулийн 33.1-д заасан хэмжээнээс багагүй зардал бүхий хайгуулын ажлыг жил бүр хийж гүйцэтгэх;

28.4.3. Ашигт малтмалын тухай хуулийн 35.2, 37.2, 38.1, 48.8-т заасан үүргийг биелүүлэх;

28.4.4. Ашигт малтмалын тухай хуулийн 48.1-д заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргаж төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

28.4.5. Ашигт малтмалын тухай хуулийн 48.3-т заасны дагуу ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн нэгдсэн тайланг батлагдсан маягт, шаардлагад нийцүүлэн боловсруулж, анхдагч материалын хамт төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх.

28.5. Энэ хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 28.1-д зааснаас гадна дараахь эрхтэй:

28.5.1. уурхайн талбайд цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул явуулах.

28.6. Энэ хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мөн хуулийн 28.2-т зааснаас гадна дараахь үүрэгтэй:

28.6.1. тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах;

28.6.2. тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах;

28.6.3. уурхайн эдэлбэрээс олборлосон цацраг идэвхт ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах;

28.6.4. Ашигт малтмалын тухай хуулийн 35.3-35.5, 36.1, 36.2, 39.1, 45.1, 45.2, 47.1, 47.5, 47.6, 48.7-48.10-т заасан үүргийг биелүүлэх;

28.6.5. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6-д заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг батлагдсан маягтын дагуу хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргаж төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.

28.7. Энэ хуулийн 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 54, 55 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн хүсэлтээр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, хяналтын дор бүхэлд нь,

эсхүл хэсэгчлэн буцаан өгч болох бөгөөд хүсэлт гаргах өргөдлийн маягтыг төрийн захиргааны байгууллага батална.

28.8. Баталгааны гэрээнд холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цөмийн материалын тоо, хэмжээ, түүнд орсон өөрчлөлт, алдагдал, хоргодол, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг зааврын дагуу тогтоосон хугацаанд төрийн захиргааны байгууллагад үнэн зөвөөр гаргаж өгөх үүрэгтэй.

28.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулна.

28.10. Энэ хуулийн 28.9-д заасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдлийг харгалзан цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОРД АШИГЛАХ ГЭРЭЭ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ

29 дүгээр зүйл. Орд ашиглах гэрээ

29.1. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноос хойш 60 хоногт багтаан түүнийг эзэмшигчтэй орд ашиглах гэрээ байгуулна.

29.2. Орд ашиглах гэрээний хугацаа тусгай зөвшөөрлийн хугацаатай адил байна.

29.3. Орд ашиглах гэрээнд дараахь зүйлийг заавал тусгана:

29.3.1. цацраг идэвхт ашигт малтмалын орд ашиглах үндэслэл;

29.3.2. цацраг идэвхт ашигт малтмалын орд ашиглах хугацаа, цацраг идэвхт ашигт малтмалын нэр төрөл, агуулга, нөөцийн хэмжээ;

29.3.3. техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан технологи, үйлдвэрлэлийн хүчин чадал, олборлох бүтээгдэхүүний тоо хэмжээ;

29.3.4. бүтээгдэхүүн борлуулах нөхцөл;

29.3.5. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх зардлын хэмжээ;

29.3.6. уурхайг хаах ерөнхий төлөвлөгөө;

29.3.7. гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлага.

29.4. Энэ хуулийн 29.1-д заасан хугацаанд орд ашиглах гэрээг байгуулаагүй бол төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

30 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын гэрээ

30.1. Энэ хуулийн 15.1.2, 15.1.5, 15.1.6-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хөрөнгө оруулагч өөрөө хүсэлт гаргавал үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нь тодорхой хугацаанд тогтвортой байлгах зорилгоор түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээг 10 хүртэл жилийн хугацаатай байгуулж болох бөгөөд түүнд Ашигт малтмалын тухай хуулийн 29.1.1-29.1.9-д заасан зүйлийг тусгана.

30.2. Энэ хуулийн 30.1-д заасан гэрээг 10 хүртэл жилийн хугацаагаар сунгаж болно.

30.3. Энэ хуулийн 30.1-д заасан гэрээг хөрөнгө оруулагчтай Засгийн газар байгуулахдаа Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөнө.

31 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах

31.1. Хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 30.1-д заасан гэрээ байгуулах хүсэлт, гэрээний төслийг төрийн захиргааны байгууллагад ирүүлэх бөгөөд түүнд эхний 5 жилд оруулах хөрөнгийн хэмжээ, хугацаа, үйлдвэрийн хүчин чадал, бүтээгдэхүүний нэр төрөл, орд ашиглах арга, технологийн талаархи мэдээлэл, эдийн засгийн үндэслэлийг хавсаргана.

31.2. Энэ хуулийн 15.1.3, 15.1.4, 15.1.6, 15.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд гэрээ байгуулах хүсэлт, гэрээний төсөлд мөн хуулийн 31.1-д заасан зүйлээс гадна тухайн ордын нөөцийг улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тухай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг хавсаргана.

31.3. Төрийн захиргааны байгууллага нь хөрөнгө оруулагчийн хүсэлт, гэрээний төсөл, хавсаргасан баримт бичгийг энэ хуулийн 31.1-д заасны дагуу хянаж, шаардлага хангасан тохиолдолд хүсэлт гаргасан этгээдэд 14 хоногт багтаан бичгээр мэдэгдэнэ.

31.4. Төрийн захиргааны байгууллага нь хөрөнгө оруулагчийн хүсэлт, гэрээний төсөл, хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 3 сарын дотор хянаж бөгөөд шаардлагатай тохиолдолд зохих байгууллага, мэргэжилтний санал, дүгнэлтийг үндэслэн дахин 3 сар хүртэлх хугацаагаар нэмэлт тодруулга хийсний үндсэн дээр хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулна.

31.5. Энэ хуулийн 30.1-т заасны дагуу хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсны дараа төрийн захиргааны байгууллага уг гэрээний нөхцөлийн тухай мэдэгдлийг Монголбанк болон холбогдох бусад байгууллагад хүргүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТАВИХ ШААРДЛАГА

32 дугаар зүйл. Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах

32.1. Цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглах, ашиглалтаас гаргах, цөмийн материалыг тээвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг биет хамгаалалтгүйгээр эрхлэхийг хориглоно.

32.2. Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах үйл ажиллагааны биет хамгаалалтад төрийн захиргааны байгууллага, улсын байцаагч хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

32.3. Цацрагийн аюулгүй байдлыг хангахад дараахь үндсэн шаардлагыг биелүүлнэ:

32.3.1. үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх;

32.3.2. шарлагын тунг зохистой хэмжээний хамгийн доод түвшинд байлгах;

32.3.3. хүн ам, үүний дотор цацрагтай ажиллагчийг шарлагын тунгийн тогтоосон хязгаараас илүүгээр өртүүлэхгүй байх.

33 дугаар зүйл. Цөмийн материал ашиглахад тавих үндсэн шаардлага

33.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт зэвсгийн зориулалттай цөмийн материалыг боловсруулах, үйлдвэрлэх, бусад аргаар олж авах, эзэмших, хадгалахыг хориглоно.

33.2. Зэвсгийн зориулалттай цөмийн материалыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно.

33.3. Төрийн захиргааны байгууллага цөмийн материалыг бүртгэх, хянах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хэрэгжилтэнд хяналт тавина.

33.4. Цөмийн материалыг бүртгэх, хянах журмыг Засгийн газар батална.

34 дүгээр зүйл. Цацраг идэвхт ашигт малтмал ашиглахад тавих үндсэн шаардлага

34.1. Улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрөлгүйгээр цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, экспортлох, импортлох, тээвэрлэх, цацраг идэвхт хаягдлыг булшлах, цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээхийг хориглоно.

34.2. Энэ хуулийн 34.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх явцад хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс хамгаалах арга хэмжээг үг үйл ажиллагааг эрхэлж байгаа иргэн, компани өөрийн зардлаар хэрэгжүүлнэ.

35 дугаар зүйл. Цөмийн эрчим хүчний эх үүсвэр ашиглахад тавих үндсэн шаардлага

35.1. Цөмийн эрчим хүчийг энэ хуулийн 35.2-т заасны дагуу баталгаажуулсан хэмжих багажгүйгээр үйлдвэрлэхийг хориглоно.

35.2. Энэ хуулийн 15.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч мөн хуулийн 35.1-д заасан хэмжих багажийг жил бүр стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулна.

35.3. Энэ хуулийн 15.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сар бүрийн 10-ны дотор өмнөх сард үйлдвэрлэсэн цөмийн эрчим хүчний хэмжээг төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.

36 дугаар зүйл. Цацрагийн үүсгүүр ашиглахад тавих үндсэн шаардлага

36.1. Цацрагийн үүсгүүрийг ашиглахад дараахь шаардлагыг биелүүлнэ:

36.1.1. цацрагийн үүсгүүрийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор цацрагийн

хяналтын болон тагнуулын төв байгууллагад мэдэгдэж бүртгүүлэх;

36.1.2. цацрагтай холбогдсон үйл ажиллагааг цацрагийн аюулгүйн стандартыг бүрэн хангасан, улсын байцаагчийн зөвшөөрсөн зориулалтын байранд явуулах;

36.1.3. цацрагийн үүсгүүр ашиглах явцад ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангаж ажиллах;

36.1.4. цацрагтай холбогдсон үйл ажиллагааны онцлог тохирсон цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, цацрагийн ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг улсын байцаагчаар хянуулж, баталгаажуулан мөрдөх;

36.1.5. цацрагийн үүсгүүрийн ашиглалтын бүртгэл хөтөлж, жилийн эцсийн тооллогын дүн, дотоод хяналтын тайлан, мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

36.1.6. цацрагийн үүсгүүр ашиглах явцад гарсан осол, зөрчлийг цацрагийн хяналт, онцгой байдал, тагнуул, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдээлэх, ослын хор уршгийг арилгах, аюулгүй болгох арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх;

36.1.7. цацрагтай ажиллагчийг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн тусгай хөтөлбөрийн дагуу явагдах цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын сургалтад хамруулж, гэрчилгээ олгох;

36.1.8. чанарын баталгаажилтын болон хэмжилтийн шаардлага хангасан цацрагийн хэмжилтийн багажаар хангагдсан байх.

36.2. Нэр төрөл, шинж чанар, идэвхийн хэмжээ, хэрэглэх зориулалт, аргачлал нь тодорхой бус цацрагийн үүсгүүрийг ашиглахыг хориглоно.

37 дугаар зүйл. Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг экспортлох, импортлоход тавих үндсэн шаардлага

37.1. Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг экспортлоход дараахь шаардлагыг биелүүлнэ:

37.1.1. шилжүүлж байгаа цөмийн материалыг олон улсын баталгаанд хамруулсан байх;

37.1.2. хүлээн авч байгаа улс нь өөрийн ашиглаж байгаа бүх цөмийн материал, цөмийн төхөөрөмжийг олон улсын баталгаанд хамруулсан байх;

37.1.3. өмнө нь шилжүүлэн авсан цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг 3 дахь улсад шилжүүлэхийн өмнө төрийн захиргаанд байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авах;

37.1.4. цөмийн материалын биет хамгаалалт нь Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай Венийн конвенцид заасан шаардлагыг хангасан байх;

37.1.5. цөмийн материалыг хүлээн авч байгаа улс нь түүнийг зөвхөн энхийн зорилгоор ашиглах тухай нотолгоо ирүүлсэн байх;



37.1.6. цөмийн материалыг хүлээн авах эцсийн хэрэглэгчийн талаархи мэдээлэл, энхийн зорилгоор ашиглах тухай холбогдох нотолгоо, мэдээллийг төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн байх.

37.2. Цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг импортлоход дараахь шаардлагыг биелүүлнэ:

37.2.1. Монгол Улсын хуулиар хориглосон цөмийн материал, цацрагийн үүсгүүр, тоног төхөөрөмж, технологийг импортлохгүй байх;

37.2.2. цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг импортлох нь Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагыг бүрэн хангасан, холбогдох эрх бүхий байгууллагаас зохих хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөлтэй байх;

37.2.3. импортлож байгаа цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийн эцсийн хэрэглэгч нь тухайн материалыг аюулгүй ашиглах удирдлагын болон техникийн чадавхитай, хангалттай нөөц бололцоотойгоо нотолсон мэдээллийг төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн байх.

38 дугаар зүйл. Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг хадгалахад тавих үндсэн шаардлага

38.1. Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг тусгай зөвшөөрөлд заасан зориулалтын хадгалах байранд хадгална.

38.2. Эзэнгүй буюу хаягдсан, олдмол цацраг идэвхт материалыг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр, хяналтын дор энэ хуулийн 11.3-т заасан тусгай байгууламжид үнэ төлбөргүй шилжүүлнэ.

38.3. Технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон, эсхүл ашиглагдахгүй байгаа цацрагийн үүсгүүрийг энэ хуулийн 11.3-т заасан тусгай байгууламжид хадгалуулна.

39 дүгээр зүйл. Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг тээвэрлэхэд тавих үндсэн шаардлага

39.1. Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг тээвэрлэхэд цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журмыг мөрдөнө.

39.2. Цөмийн материал болон цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн улс хоорондын тээврийг олон улсын холбогдох гэрээ, хэлэлцээр, дүрмийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

39.3. Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журмыг Засгийн газар батална.

40 дүгээр зүйл. Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг худалдах, худалдан авахад тавих үндсэн шаардлага

40.1. Цөмийн материалыг энэ хуулийн 15.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад этгээд худалдах, худалдан авахыг хориглоно.

40.2. Цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг энэ

хуулийн 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад этгээд худалдах, худалдан авахыг хориглоно.

41 дүгээр зүйл. Цөмийн материал болон цацрагийн үүсгүүрийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих үндсэн шаардлага

41.1. Цөмийн материалыг энэ хуулийн 15.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад этгээд улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

41.2. Цацрагийн үүсгүүр, цацрагийн үүсгүүртэй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг энэ хуулийн 15.1.8-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээс бусад этгээд улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

42 дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт материалыг хаягдал болгох, устгах, булшлахад тавих үндсэн шаардлага

42.1. Цөмийн болон цацраг идэвхт материалыг хаягдал болгох, устгах, булшлахад олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журмыг мөрдөнө.

42.2. Цөмийн болон цацраг идэвхт материалыг улсын байцаагчийн дүгнэлт, тусгай зөвшөөрөлгүйгээр булшлах, хаягдал болгохыг хориглоно.

42.3. Цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлахад дараахь үндсэн шаардлагыг биелүүлнэ:

42.3.1. цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлахад олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журмыг чанд мөрдөх;

42.3.2. цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлах ажлыг холбогдох эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрлөөр улсын байцаагчийн хяналтын дор гүйцэтгэх.

42.4. Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.

43 дугаар зүйл. Мэргэжлийн шарлагад тавих үндсэн шаардлага

43.1. Цацрагтай ажиллагч нь мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтанд хамрагдана.

43.2. Мэргэжлийн шарлагын хяналтыг гүйцэтгэж байгаа байгууллага нь хувийн тунгийн нэгдсэн бүртгэлийг архивт 50 жил хадгална.

43.3. Цацрагтай ажиллагчийг цацрагийн аюулгүйн стандартад заасан шарлагын тунгийн хязгаараас илүүгээр өртүүлэхийг хориглоно.

43.4. Цацрагтай ажиллагч нь цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын шаардлага, хөдөлмөрийн хэвийн нөхцөлийг хангах асуудлаар байгууллагын захиргаанд шаардлага тавих, ажиллахаас татгалзах, төрийн захиргааны байгууллагад гомдлоо гаргах эрхтэй.

43.5. Цацрагтай ажиллагч нь мэргэжлээс шалтгаалах өвчний эмнэлгэнд тогтмол хяналтанд байж, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдана.

43.6. Шаардлагатай бол цацрагтай ажилладаг жирэмсэн эмэгтэй Хөдөлмөрийн тухай

хуулийн¹² 107 дугаар зүйлд заасны дагуу ажлын нөхцөлөө өөрчлөх эрхтэй бөгөөд энэ нь түүнийг ажлаас халах үндэслэл болохгүй.

43.7. Цацрагтай холбогдсон ажилд 18 насанд хүрээгүй хүнийг авч ажиллуулахыг хориглоно.

43.8. Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамрагдаж байгаа цацрагтай ажиллагчийн ажлын нөхцөл нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд хамаарна.

44 дүгээр зүйл. Эмнэлгийн шарлагад тавих үндсэн шаардлага

44.1. Эмнэлгийн шарлага хийхэд дараахь шаардлагыг биелүүлнэ:

44.1.1. цацрагийн үүсгүүрээр оношлогоо, эмчилгээ хийхдээ энэ хууль, цацрагийн аюулгүйн стандарт болон бусад холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллах;

44.1.2. цацрагийн үүсгүүрээр оношлогоо, эмчилгээ хийж байгаа этгээд нь ашиглаж байгаа багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид тохируулга, чанарын хяналтыг тогтмол хийж байх;

44.1.3. хүүхдэд цацрагийн үүсгүүрээр оношлогоо, эмчилгээ хийхдээ түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг авсан байх;

44.1.4. эмчилгээ, оношлогооны үед өвчтөнийг цацрагийн аюулгүйн стандартад заасан тунгийн хязгаараас илүү шарлагад өртүүлэхийг хориглох;

44.1.5. эмчилгээ, оношлогооны үед өвчтөний биеийн бусад хэсгийг шарлагаас хамгаалах, өвчтөний асран хамгаалагч болон туслах ажилтны хувийн хамгаалах хэрэгсэлээр хангах;

44.1.6. цацрагийн эмчилгээ, оношлогооны үед бусад өвчтөнийг шаардлагагүй нэмэгдэл шарлагад өртүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН ОСЛООС СЭРГИЙЛЭХ, ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ

45 дугаар зүйл. Цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх

45.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цөмийн болон цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, ослын хор уршгийг арилгах, аюулгүй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөртэй байх бөгөөд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

45.2. Цөмийн болон цацрагийн ослын шалтгаан, түвшнийг тогтоох, ослын хор уршгийг арилгах ажлыг Улсын байнгын онцгой комиссын удирдлага дор төрийн захиргааны байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

45.3. Нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн ослын хор уршгийг арилгах ажлын зардлыг Засгийн газар хариуцна.

46 дугаар зүйл. Цөмийн болон цацрагийн ослын улмаас үүссэн хохирлыг арилгах

46.1. Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийг зөрчсөний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол учруулсан бол үг хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

46.2. Энэ хуулийн 46.1-д заасан тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 30 жилийн хугацаанд дахин тусгай зөвшөөрөл олгохгүй.

ДОЛДУГААР БҮЛЭГ ОЛОН УЛСЫН БАТАЛГАА БОЛОН ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

47 дугаар зүйл. Олон улсын баталгаа хэрэглэх

47.1. Энэ хуулийн 15.1.1-15.1.4-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олон улсын баталгаа хэрэглэх асуудлаар Олон улсын атомын энергийн агентлагтай дараахь чиглэлээр хамтран ажиллана:

47.1.1. энэ хуулийн 28.8-д заасны дагуу цөмийн материалын тоо, хэмжээ, түүнд орсон өөрчлөлт, алдагдал, хорогдол, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг төрийн захиргааны байгууллагаар дамжуулан тогтоосон хугацаанд хүргүүлэх;

47.1.2. баталгааны гэрээний дагуу Олон улсын атомын энергийн агентлагийн шинжлэгч, байцаагчийн хяналт шалгалтын ажилд дэмжлэг, тусалцаа үзүүлж, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох талаар тавьсан шаардлагыг биелүүлэх.

48 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналт

48.1. Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд төрийн захиргааны байгууллага, эрх бүхий улсын байцаагч хэрэгжүүлнэ.

49 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналт

49.1. Цөмийн энергийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналтыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд иргэн, хуулийн этгээд хэрэгжүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

50 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

50.1. Цөмийн энергийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын

¹² Хөдөлмөрийн тухай хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн



байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь хариуцлага хүлээлгэнэ:

50.1.1. энэ хуулийн 5 дугаар бүлэгт заасан цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой аюулгүй ажиллагааны шаардлагыг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10, компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, үйл ажиллагааг нь 3 хүртэл сарын хугацаагаар түр, хэсэгчлэн зогсоох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

50.1.2. шаардлагатай мэдээ, тайланг гаргаж өгөөгүй буюу цацрагтай ажиллагчийг мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамруулаагүй иргэний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-3, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5, компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож;

50.1.3. тусгай зөвшөөрөлгүйгээр буюу тусгай зөвшөөрөлд заасныг зөрчиж үйл ажиллагаа явуулсан, энэхүү үйл ажиллагаанаас учирсан хохирлыг арилгах арга хэмжээ аваагүй, цацрагийн осол, зөрчлийн тохиолдлыг төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллагад зохих журмын дагуу мэдэгдээгүй бол хууль бусаар олсон орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж, зөрчил гаргасан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-15, компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15-25 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож;

50.1.4. төрийн захиргааны байгууллагад худал мэдээлэл гаргаж өгсөн, цацрагийн үүсгүүрийн нэр төрлийг өөрчилсөн, хүн ам, нийгэм, байгаль орчинд хохирол учруулсан, эсхүл хохирол учруулахуйц ноцтой нөхцөл байдал бий болгосон, удаа дараа ноцтой зөрчил давтан гаргасан, илрүүлсэн зөрчлийг арилгаагүй тохиолдолд үйл ажиллагааг түр, хэсэгчлэн зогсоох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

50.1.5. энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-8, компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 8-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;

50.1.6. тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-3, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5, компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож;

50.1.7. тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон цацраг идэвхт ашигт малтмалын хэмжээг нуун дарагдуулсан, энэхүү зорилгоор "Ураамч" гэрээ байгуулсан, эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж борлуулалтын орлогыг санваатайгаар бууруулсан буюу бууруулахыг завдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, олборлосон цацраг идэвхт ашигт малтмалын хэмжээ болон борлуулалтын үнийн зөрүүг тооцож улсын орлогод нөхөн төлүүлэх;

50.1.8. хайгуулын талбайгаас авсан дээж, сорьц, анхдагч материалыг санваатайгаар устгасан албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10, компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож;

50.1.9. улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, цацрагийн үүсгүүрийг хүлээн авсан тухайгаа төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж бүртгүүлээгүй, тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу сунгуулаагүй албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5, компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож.

50.2. Цөмийн энергийн тухай хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн хууль бус үйлдлийг нуух, авлига авах, хуулиар хамгаалсан төрийн, байгууллагын, хувь хүний нууц задруулах зэргээр хуулиар хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн албан тушаалтан, улсын байцаагчид хууль тогтоомжид заасны дагуу сахилын, захиргааны, эд хөрөнгийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

51 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

51.1. Энэ хуулийг 2009 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгосон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2009 оны 11 дүгээр

сарын 15-ны дотор уг хуульд заасан нөхцөл, журмын дагуу шинэчлэн бүртгэнэ.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түүнийг



шинэчлэн бүртгүүлэх тухай өргөдлийг цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд Цөмийн энергийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлага хангасан тохиолдолд түүнийг энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу бүртгэж, тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгоно.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Цөмийн энергийн тухай хуульд заасан төрийн оролцооны хувийг төрд эзэмшүүлэхийг зөвшөөрснөө нотолсон албан ёсны шийдвэрийг түүнийг шинэчлэн бүртгүүлэх тухай өргөдөлд хавсаргасан байна.

4 дүгээр зүйл. Энэ хуульд заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгүүлээгүй бол түүнийг хүчингүй болсонд тооцно.

5 дугаар зүйл. 2009 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө ирүүлсэн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг Цөмийн энергийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр баталсан Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн

тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт:

“4.1.2. “цацраг идэвхт ашигт малтмал”

гэж уран болон төрийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлалыг;”

2/7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг:

“7.6. Цөмийн энергийн тухай

хуулийн дагуу цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрөл олгох шалгаруулалт явуулахаар цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэл ирүүлсэн бол тухайн талбай дээр уг асуудлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.”

3/21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт:

“21.1.2. хайгуулын талбайн хилийн

дотор цацраг идэвхт ашигт малтмалыг цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрэх, хайх;”

4/27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалт:

“27.1.2. тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа цацраг идэвхт ашигт малтмалыг цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах;”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай

хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15, 11.1.16, 11.1.20 дахь заалтын “тусгай” гэсний өмнө “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын” гэж, мөн зүйлийн 11.1.19 дэх заалтын “хайгуулын” гэсний өмнө “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийн “болон” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж, мөн зүйлийн 21.1.1 дэх заалтын “дагуу” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж, мөн зүйлийн 21.1.2 дахь заалтын “хэсэгт” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж, мөн зүйлийн 21.1.3 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалтын “дээр” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалтын “тохиолдолд” гэсний дараа “цацраг идэвхт ашигт малтмалаас бусад



төрлийн ашигт малтмалын" гэж, 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын "байгаа" гэсний дараа "цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн" гэж, мөн зүйлийн 27.1.3 дахь заалтын "олборлосон" гэсний дараа "цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн" гэж, мөн зүйлийн 27.1.4 дэх заалтын "талбайд" гэсний дараа "цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн" гэж, мөн зүйлийн 27.1.6 дахь заалтын "ашиглалтын" гэсний өмнө "цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн "байгалийн хийгээс" гэснийг "байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмалаас" гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн "4.1.11-д" гэснийг "4.1.12-г" гэж, 4

дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтын "4.1.14-г" гэснийг "4.1.15-д" гэж, мөн зүйлийн 4.1.17 дахь заалтын "4.1.15-д" гэснийг "4.1.16-д" гэж, мөн зүйлийн 4.1.2-4.1.21 дэх заалтын дугаарыг "4.1.3-4.1.22" гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.2-21.1.7 дахь заалтын дугаарыг 21.1.3-21.1.8 гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн "21.1.4-г" гэснийг "21.1.5-д" гэж, 27 дугаар зүйлийн 27.1.2-27.1.10 дахь заалтын дугаарыг "27.1.3-27.1.11" гэж, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн "27.1.6-д" гэснийг "27.1.7-д" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр

**Улаанбаатар
хот**

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:
1/7 дугаар зүйлийн 7.3.9-7.3.12 дахь

заалт:

"7.3.9. цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж;

7.3.10. цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж;

7.3.11. цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар нөхөн сэргээх тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж;

7.3.12. цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, идэвхийг сулруулах болон түүнтэй

::элбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж."

2/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:

"8.3. Энэ хуулийн 7.3.9-7.3.12-т заасан татварын хувь, хэмжээг Засгийн газар тогтооно."

2 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.4 дэх заалтын "улсын" гэсний өмнө "энэ хуулийн 7.3.9-7.3.12-т зааснаас бусад" гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн "хуулийн" гэсний дараа "7.3.9-7.3.12," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн "8.3, 8.4" гэснийг "8.4, 8.5" гэж, мөн зүйлийн 8.3, 8.4 дэх хэсгийн дугаарыг "8.4, 8.5" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр

**Улаанбаатар
хот**

МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6, 7 дахь хэсэг нэмсүгэй:

"6.Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах, цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, цацраг идэвхт ашигт малтмал

импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар нөхөн сэргээх, цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл

ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээнд хамаарахгүй.

7. Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх

хэсгийн “хуулийн 15.1” гэснийг “зүйлийн 1 дэх хэсэг” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 15.18 дахь хэсэг нэмсүгэй:

“15.18. Цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн чиглэлээр:

15.18.1. цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;

15.18.2. цөмийн төхөөрөмж ашиглах;

15.18.3. цөмийн бодис эзэмших, ашиглах;

15.18.4. цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах;

15.18.5. цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх;

15.18.6. цацраг идэвхт ашигт малтмал ашиглах;

15.18.7. цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар сэргээх;

15.18.8. цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.”

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсгийн “Ашигт малтмалын тухай,” гэсний дараа “Цөмийн энергийн тухай,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.8.1 дэх заалт, 16.1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтын “тохиолдсон” гэсний дараа “, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 2 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг:

“2.3. Цөмийн эрчим хүч ашиглахтай холбогдсон харилцааг Цөмийн энергийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.”

2/3 дугаар зүйлийн 3.1.21-3.1.23 дахь заалт:



"3.1.21. "цөмийн эрчим хүчний нөөц" гэж эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор цөмийн эрчим хүчний эх үүсвэрт ашиглаж болох цөмийн түлшийг;

3.1.22. "цөмийн эрчим хүч" гэж цөмийн эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулааныг;

3.1.23. "цөмийн эрчим хүчний эх үүсвэр"

гэж цөмийн эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа байгууламжийг.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 16.1.10 дахь заалт нэмсүгэй:

"16.1.10. цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 07 дугаар
сарын 16-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Компанийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсгийн "бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх зөвлөл-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ" гэснийг " эсхүл хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх зөвлөл-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож

байгаа хувь нийлүүлэгчдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно" гэж, 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсгийн "Компанийн" гэснийг "Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл компанийн" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр**

**Улаанбаатар
хот**

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 12 дугаар зүйлийн 12.1.7 дахь заалт:

"12.1.7. экспортод гаргасан уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн."

2/ 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг:

"12.5. Энэ хуулийн 12.1.7-д заасан экспортод гаргасан уул уурхайн эцсийн бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал, кодыг Засгийн газар тогтоосно."

3/ 13 дугаар зүйлийн 13.1.16 дахь заалт:
"13.1.16. энэ хуулийн 12.1.7-д зааснаас бусад уул уурхайн бүтээгдэхүүн."

2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн "30 хувиас" гэснийг "15 хувиас" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Иргэний хуулийн 10, 11 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Иргэний хуулийн /цаашид хууль гэх/ 10, 11 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мйр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийг 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:**

1. Хуулийн 85 дугаар зүйлийн 85.2.-т заасан газрын үндсэн бүрдэл хэсэгт хамаарах **"байшин, барилга байгууламж болон бусад зүйл"** гэдэгт хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3.-т заасан үл хөдлөх, 119 дүгээр зүйлийн 119.1-д заасан хөдлөх эд хөрөнгийн аль алиныг хамааруулан ойлгоно.

2. Хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1.-д **"хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ"** гэж зааснаар зөвхөн хууль болон гэрээнд заасан үндэслэлээр үүссэн эзэмшил нь эрх зүйн үр дагавар буюу шаардах эрхийг үүсгэнэ.

3. Хуулийн 90 дүгээр зүйлийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

3.1. Энэ зүйлийн 90.1.-д заасан **"шударга эзэмшигч"** гэдэгт мөн зүйл, хэсэгт заасан этгээдээс гадна өөрийн эзэмшлийг хууль ёсны гэж ойлгож, эзэмшлээ хууль бус болохыг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан хууль бус эзэмшигчийг хамааруулж болно.

Хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1.-д эзэмшил нь эд юмсыг зөвхөн хууль ёсоор мэдэлдээ авах замаар үүсэхээр заасан боловч мөн хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1., 94.3., 493 дугаар зүйлийн 493.6.-д заасан зохицуулалтын агуулгаар хууль бусаар олсон эзэмшил нь шударга, шударга бус гэсэн хэлбэртэй байна.

3.2. Мөн зүйлийн 90.2.-т заасан шаардах эрхийн хугацааг хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.-т заасан тусгай хугацаа гэж ойлгох ба энэ хугацаа Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1.-д заасан шаардлагад мөн адил хамаарна. Харин гэрээний үүрэгтэй холбоотой эзэмшлийн тухай шаардлагад хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1., 75.2.2.-т заасан хугацааг баримтална.

3.3. Энэ зүйлийн 90.3.-т зааснаар эд хөрөнгийг шинэ эзэмшигчээс шаардах мөн зүйлийн 90.2.-т заасан эрхийг шударга эзэмшигч зөвхөн шинэ эзэмшигчээс илүү эрхтэй байж эдлэнэ. Тухайлбал, шинэ эзэмшигч шударга эзэмшигчийг хууран мэхлэх, хүч хэрэглэх замаар эд хөрөнгийг нь мэдэлдээ аваагүй л бол шударга эзэмшигч хүсэл зоригоосоо гадуур алдсан эд хөрөнгөө хариу төлбөртэй авсан шинэ эзэмшигчээс хуулийн 93 дугаар зүйлийн 93.1.-д заасан зарчмын дагуу шаардах эрхгүй.

4. Хуулийн 92 дугаар зүйлийн 92.1.-д заасан **"хэн нэгэн этгээд"** гэдэгт аливаа бусад этгээдээс гадна тухайн эд хөрөнгийн өмчлөгчийг хамааруулж үзнэ.

5. Хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1.-д заасан **"эрх бүхий этгээдэд буцаан өгөх үүрэг"** нь мөн хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1.-д заасан үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнөөс үүсэх үүрэгт хамаарна.

6. Мөн зүйлийн 94.1., 94.2., 94.3., 94.6., 95 дугаар зүйлийн 95.1., 95.2.-т тус тус заасан **"эрх бүхий этгээд"** гэдэгт шударга эзэмшигчээс илүү буюу тухайн эд хөрөнгийг хууль, гэрээний дагуу эзэмших эрхтэй этгээдийг ойлгоно.

Энэ зүйлийн 94.2.-т заасан **"буцааж авах хүртэл"** гэж эд хөрөнгө шударга эзэмшигчээс эрх бүхий этгээдэд шилжих хүртэлх хугацааг хэлнэ.

7. Мөн зүйлийн 94.5.-д заасан **"төлбөл зохих төлбөр"** гэдэгт энэ зүйлийн 94.3.-т заасан зардлыг ойлгоно.

8. Энэ зүйлийн 94.6.-д заасан саатуулах эрх нь мөн зүйлийн 94.3.-т заасан шаардлагад хамаарна.

9. Хуулийн 95 дугаар зүйлийн 95.1.-д заасан **"шударга бус эзэмшигч"** гэж эзэмшлээ хууль бус болохыг мэдсэн буюу мэдэх боломжтой байсан хууль бус эзэмшигчийг хэлнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Б.УНДРАХ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын

Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12

Төрийн ордон-126 тоот

и-мэйл: turin_medeelel@parliament.mn



262420, 329612

Индекс 14003



329487

Хэвлэлийн хуудас 2.5